



МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

20 ²¹ он ¹⁰ сарын ²⁶ -ны өдөр дугаар

Дугаар ХЭГ/2537

Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Т.ДОРЖХАНД ТАНАА

Асуулгын хариу хүргүүлэх тухай

Сайжруулсан шахмал түлшний хомсдол үүссэн асуудлаар Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан асуулгын хариуг Танд хүргүүлж байна.

Хүлээн авч, танилцана уу.

Хавсралт: ... хуудастай.

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга



Ц.НЯМДОРЖ

000021514412

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
2021 оны 10 дугаар сарын 26 -ны өдрийн
ХТБ.37 дугаар албан бичгийн хавсралт

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН Т.ДОРЖХАНДААС МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДАД ТАВЬСАН АСУУЛГЫН ХАРИУ

Асуулга 1.Сайжруулсан шахмал түлшний хомсдол үүсээд байгаа өнөөгийн бодит шалтгаан, нөхцөлийн талаар:

2021 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн байдлаар сайжруулсан шахмал түлшний түүхий эд /мидлинг/-ийн нөөц Төв аймагт байрлах дундын бүсэд 131,663 тонн, баруун бүсийн үйлдвэрт 53,443 тонн, зүүн бүсийн үйлдвэрт 20,608 тонн буюу нийт 204,307 тонн, барьцалдуулагч бодисын нөөц 2,142 тонн байна. Сайжруулсан шахмал түлшний нөөц 6 дүүргийн 73 агуулахад 56,780.1 тонн, баруун бүсийн үйлдвэрийн талбайд 3,373.8 тонн, зүүн бүсийн үйлдвэрийн талбайд 5,610.7 тонн буюу нийт 65,764.6 тонн байна.

“Таван толгой түлш” ХХК нь 2021-2022 оны өвөлжилтийн бэлтгэлийг хангах ажлын хүрээнд үйлдвэрийн тоног төхөөрөмж их засварын ажлыг гүйцэтгэн 2021 оны 08 дугаар сарын 02-ны өдрөөс шугамуудыг үе шаттайгаар ажиллагаанд оруулж сайжруулсан шахмал түлш нөөцлөх ажлыг эхлүүлсэн.

Сайжруулсан шахмал түлшний борлуулалт эхэлсэн өдөр буюу 2021 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн байдлаар сайжруулсан шахмал түлш 69,851 тонн буюу 29 хоногийн (өвлийн оргил ачааллын 19 хоног) нөөц, барьцалдуулагч 682 тонн буюу 10 хоногийн нөөц бүрдүүлээд байсан.

Түлшний үйлдвэрлэл, нөөц бүрдүүлэх ажилд доголдол үүсээгүй бөгөөд өнгөрсөн оны мөн үетэй дүйцүүлэн 2021 оны 9 дүгээр сарын 27-ны өдрөөс 128 цэгээр сайжруулсан шахмал түлшний борлуулалтыг эхлүүлсэн нь иргэдийг сайжруулсан шахмал түлш худалдан авахад дараалал ихсэх шалтгаан болсон байна.

2021 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн байдлаар нийслэлийн 6 дүүрэгт байрлах 500 борлуулалтын цэгээр иргэдэд сайжруулсан шахмал түлш нийлүүлж байгаа бөгөөд өвлийн оргил ачааллын үед цэгийн тоог нэмэгдүүлж 300 өрхийн дунд 1 цэг буюу нийт 600 борлуулалтын цэгээр иргэдэд сайжруулсан шахмал түлш нийлүүлэхээр төлөвлөсөн.

Эрчим хүчний яамнаас “Таван толгой түлш” ХХК-ийн үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавин ажиллаж байгаа бөгөөд одоогийн байдлаар тус компани хоногт 2,700 тонн сайжруулсан шахмал түлш үйлдвэрлэж, хоногт 2,000 тонн сайжруулсан шахмал түлш иргэдэд хэвийн нийлүүлж байна.

Асуулга 2.Иргэд амь нас, эрүүл мэндээрээ хохирох энэхүү нөхцөл байдалд хүргэсэн албан тушаалтнуудад хэрхэн хариуцлага хүлээлгэх гэж байгаа талаар:

“Таван толгой түлш” ХХК-ийн сайжруулсан шахмал түлшний үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас шалтгаалж иргэд эрүүл мэнд, амь насаараа хохирсныг хууль

хяналтын байгууллагаас тогтоож, гэм буруутай нь хууль тогтоомжид заасны дагуу нотлогдсон тохиолдолд тухайн албан тушаалтанд Хөдөлмөрийн болон Компанийн тухай хуульд заасан зохих хариуцлагыг хүлээлгэх саналаа тус компанийн төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэх хүрээнд хүргүүлж ажиллах болно.

Асуулга 3.Өвөлжилтийн бэлтгэл ажил, сайжруулсан шахмал түлшний хангамжийг хэвийн болгох талаар Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар:

Монгол Улсын Ерөнхий сайдын 2021 оны 10 дугаар сарын 6-ны өдрийн 152 дугаар захирамжаар 2021-2022 оны өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд сайжруулсан шахмал түлшний үйлдвэрлэлд шаардлагатай түүхий эдээр хангах, үйлдвэрлэлийн хэвийн үйл ажиллагааг тогтворжуулах, нийслэлийн хэрэглэгчдийг сайжруулсан түлшээр хангахад салбар хоорондын уялдаа холбоог шуурхай удирдлагаар хангаж ажиллах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулан шуурхай зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллаж байна.

Мөн Засгийн газрын 2020 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн хуралдаанаар “Таван толгой түлш” ХХК-ийн төрийн хувь эзэмшлийг тодорхойлж, төрийн эзэмшлийн 51%-ийг “Эрдэнэс Тавантолгой” ХК-д, 39%-ийг Эрчим хүчний яаманд, 10%-ийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт тус тус эзэмшүүлэхээр шийдвэрлэсэн.

-----oO-----